



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/136.

Зуунмод

Үнэлгээний ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тогтоол, 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд зудын эрсдэл өндөр түвшинд үнэлэгдэж, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан үүсэж болзошгүй уруйн болон шар усны үерийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Э.Саран-Эрдэнэ	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
М.Эрдэнэсайхан	(Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, ахмад)
Б.Баянмөнх	(Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)
С.Мөнхтуяа	(Эрүүл мэндийн газрын дарга)
Н.Гантулга	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Ж.Даш-Яйчил	(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
Д.Батцэцэг	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Ц.Нарантуяа	(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
Э.Гэрэлцогт	(Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга)
Ж.Отгончулуун	(Статистикийн хэлтсийн дарга)
	(Сумдын Засаг дарга нар)

Нарийн бичиг:

Б.Бадмаараг (Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

2.Аймгийн хэмжээнд тохиолдож болзошгүй гамшгийн төрөл тус бүрээр урьдчилсан болон нөхцөл байдлыг харгалзан шат дараалсан байдлаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, зааврын дагуу ерөнхий үнэлгээг хийж, үр дүн, хариу арга хэмжээний зөвлөмжийг тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (Г.Сурмаа)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР